**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР 2025 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

| № | Аймгийн Засаг даргын эрх, үүрэг | БИЕЛЭЛТ |
|---|---|---|
| **3.1 Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | | |
| 3.1.1. | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулж, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг дэмжинэ. | “Гэр бүлийн боловсрол” олгох ажлын хүрээнд “Угийн бичиг хөтлөлт”-ийн арга зүй өгөх сургалтад байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-үүдтэй хамтран 9 байгууллагын 86 албан хаагчийг хамруулсан. Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн хамтарсан “Угийн бичиг-Удмын хэлхээ” 1 сарын аяны хүрээнд 2025 оны 11 сарын 03-ны өдрийн “Сургагч багш” бэлтгэх сургалтад ХГБХХГазраас 1 сургагч багш бэлтгэгдсэн.<br>“Гэр бүлээрээ гэрэл цацруулья” өдөрлөгийн хүрээнд ажилтнууд гэр бүлийн хамт угийн бичгийн сургалтад хамрагдаж, үндэсний бичиг соёлын хэрэглээ, өв уламжлалыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэв.Байгууллагын Facebook хуудас, sukhbaatar.hudulmur-halamj.gov.mn цахим хуудас болон ил тод байдлын самбарт нийт 157 мэдээллийг хос бичгээр байршуулж олон нийтэд түгээн ажиллав.<br>Тайлант онд албан хэрэгцээнд зориулан хос бичигтэй 400 ширхэг хэвлэмэл хуудсыг Төрийн архивын тасгаар хэвлүүлж, нийт 215 албан бичгийг хос бичгээр боловсруулан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн |
| **3.1.2** | **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд:** | |

| | | |
|---|---|---|
| 3.1.2.1. | Орон нутагт Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ | 2024 онд аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийлийн шалтгаан нөхцлийг судалж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Гэр бүлийн хүчирхийлэл, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх, таслан зогсоох зорилгоор “Гэрээр айлчлах” аянаар аймгийн нийт өрхийн 15 хувьд буюу 3917 насанд хүрэгч, 3209 хүүхэд нийт 7126 иргэн буюу нийт иргэнд хүрч ажилласан.<br>“Гэр бүлийн боловсрол” олгох сургалтаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг сурталчилан таниулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Сургалтад 56 байгууллагын 2768 албан хаагчийг хамруулсан. Монголын уламжлалт цагаан сар, Цэргийн баяр, Олон Улсын “Гэр бүлийн өдөр” зэрэг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан “Гэр бүл - Аз жаргалын эхэн” телевизийн нэвтрүүлгийг 3 дугаар бэлтгэн орон нутгийн BBS телевиз болон байгууллагын цахим хаягаар иргэдэд хүргэсэн. Хандалт 5146<br>Баруун-Урт сумын ЕБС-иудын 1-8 дүгээр ангийн 430 гаруй хүүхдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл мэдлэг олгох сургалтыг Сүхбаатар аймаг дахь Улсын өмгөөлөгчтэй хамтран зохион байгуулсан.<br><br>Эрүүл мэндийн газар, АНЭ, Цагдаагийн газартай хамтран “Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё” аяны хүрээнд “Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?” сэдэвт сургалтыг зохион байгуулж 400 өсвөр үеийнхэнийг хамруулсан.<br><br>Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх “Хүүхэд-Эрхэм хэрэглэгч” аяныг 2025.03.15–2025.05.01-нийг хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Тус аяны хүрээнд нийт 27 байгууллага өөрийн гадаад, дотоод орчны үнэлгээ хийж, гэрийн аюулгүй байдлын үнэлгээг 964 өрхөд хийснээр 3511 иргэн хамрагдсанаас 2560 хүүхдийн аюулгүй байдал хангагдсан байна. |

| | | |
|---|---|---|
| | | ШШГГ, Прокурорын газартай хамтран Шүүхээс “хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ” авагдсан 10 хүүхдийг сургалт, хүмүүжлийн арга хэмжээнд хамруулж тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br><br>ОБГ, ДБЭХС ТӨК, Баруун-Урт сумын ЗДТГ-тай хамтран “Сар шинэ” “Гэр хорооллын айл өрхийн аюулгүй галлагаа” “Хүүхдийн аюулгүй байдал” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 138 өрхөөр явж эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 15 өрхөд Хүүхэд гэр бүлийн эрсдлийг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээг хийж, кейс нээн хариу үйлчилгээг үзүүлсэн<br><br>Ерөнхий боловсролын 4 сургуультай хамтран “Олон улсын хүүхдийн эрхийн конвенцын өдрийг тохиолдуулан” “Эрхээ мэдье-Эрхээ хамгаалъя” арга хэмжээг зохион байгуулж 100 суралцагчийг хамруулсан.<br><br>Үр дүн: Хууль тогтоомжийн хүрээнд тэмдэглэлт өдрүүд болон аян, сургалт, кейсийн хариу үйлчилгээ зэрэг нийт 16 арга хэмжээгээр дамжуулан 14,902 иргэнд хүрч ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл урьд оны мөн үетэй харьцуулахад 19 хувиар буурсан үзүүлэлттэй байна. |
| 3.1.2.2. | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ амьдрах ухааны боловсрол олгох | “Түр хамгаалах байр” болон газрын дэргэдэх зөвлөгөө өгөх төв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн туслах үйлчилгээ үзүүлдэг “Тусч хүч” ТББ, Баруун-Урт сумын дэргэдэх “Зөвлөгөө өгөх төв” зэрэг төвүүдээр дамжуулан 326 иргэнд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилсан.<br><br>Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан 26 удаагийн арга хэмжээ, бүлгийн уулзалт, ганцаарчилсан зөвлөгөө зэрэгт нийт гэр бүлийн 40.1% буюу 7891 өрх, гэр бүлд хүрч ажилласан.<br><br>Мөн гэр бүлийн маргаантай асуудлаар 4 иргэн, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн өндөр настан 2, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 21, гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн 12 эцэг эх, асран хамгаалагч, гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны 12 |

| | | |
|---|---|---|
| | | хүүхэд, нийт 39 хүнд хууль зүйн зөвлөгөө өгч, хамтарсан баг болон өмгөөлөгчтэй холбон зуучлах арга хэмжээ зохион байгуулсан.<br><br>Хариу үйлчилгээнд хамрагдсан 20 өрхөд түлээ нүүрсний дэмжлэг үзүүлэв.<br><br>Үр дүн: 26 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, нийт өрхийн 40,1% буюу 7891 өрхөд хүрч ажиллан, 20 өрхөд дэмжлэг үзүүлсэн |
| 3.1.2.3. | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж батлуулах. | Гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хангах “Түр хамгаалах байр”-нд тайлант хугацаанд 47 иргэн үйлчлүүлснээс насанд хүрэгч 12 , хүүхэд 35 үүнээс эмэгтэй 22, эрэгтэй 13 байна. Хүчирхийллийн хэлбэрээр авч үзвэл: Бэлгийн хүчирхийлэл 5, Бие махбодь 12, Сэтгэл санаа 3, Үл хайхрах 27. йлчилгээнд хамрагдсан нийт иргэдэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээг үзүүлж асран халамжлахын зэрэгцээ эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн болон нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучилж хууль эрх зүйн туслалцаа болон боловсролын үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Мөн үйлчлүүлэгчдэд гар урлал болон хөгжлийн үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. 47 үйлчлүүлэгчийг гэр бүлд нь эргэн нэгтгэж харьяаллын дагуу хамтарсан багт шилжүүлж хяналт тавих зэргээр холбогдох хариу үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. “Түр хамгаалах байр”-ны алба хаагчдыг “Брайль үсэг”-ийн 14 хоногийн сургалт, MNS 7038:2024 “Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”, MNS 6040:2019 “Түр хамгаалах байрны стандарт” болон холбогдох эрх зүйн орчин, хариу үйлчилгээний арга зүйн сургалт зохион байгуулсан. Үр дүн: Түр хамгаалах байранд нийт 47 иргэн үйлчилгээнд хамрагдсанаас 45 иргэнийг гэр бүлд нь эргэн нэгтгэж, 2 иргэний аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Байрны урсгал засвар, зардлыг ИТХ-аар шийдвэрлүүлсэн. |

| | | |
|---|---|---|
| 3.1.2.4 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | Иргэдийн “Гэр бүлийн боловсрол”-г дээшлүүлэх ажлын хүрээнд “Гэр бүл-Аз жаргалын эхэн” телевизийн нэвтрүүлэг 3 удаа, подкаст 2 удаа, “Гэрээр айлчлах” аян, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд амьдрах ухааны сургалт, ОУ-ын “Гэр бүлийн өдөр”-г тохиолдуулан "Жаргалтай гэр бүл", "Цацарсан хайр", "Хүүхэд хайр ирээдүй", "Хайраас хүүхэд", "Бид бол нар", “Өрх бүр жаргалтай”, “Хайр цацарсан гэр бүл” зэрэг өдөрлөгөөр нөлөөллийн ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Хамрагдсан гэр бүл 1917<br><br>Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-өөр дамжуулан 18 арга хэмжээ зохион байгуулж, Олон улсын “Гэр бүлийн өдөр”-ийг 49 байгууллага тэмдэглэн өнгөрүүлж, 56 байгууллага “Гэр бүл боловсрол” олгох сургалт зохион байгуулж, иргэдийн гэр бүлийн боловсролын мэдлэг дээшилсэн байна.<br><br>Хойч үедээ үнэт ёс заншил, өв уламжлалаа өвлүүлэх үлдээх “Гэрлэлтийн батлах гардуулах” хүндэтгэлийн арга хэмжээнд 60 жил хамт амьдарсан ахмад гэр бүлийн “Очир Эрдэнийн хурим”-ын үйл ажиллагааг зохион байгуулж, хүндэтгэл үзүүллээ.<br><br>“Гэр бүлийн боловсрол”-ыг дээшлүүлэх, гэр бүл, хүүхэдтэй холбогдох хууль тогтоомжийг сурталчилан таниулах, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэдтэй гэр бүлд ажиллах, гэр бүлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэрээр айлчлах” аяныг зохион байгуулж, өрхүүдэд айлчлан нөхцөл байдалтай танилцаж холбогдох хууль тогтоомжоор гарын гарын авлага бэлтгэн хүргэж, шаардлагатай тохиолдлыг мэргэжлийн байгууллагад холбон зуучилсан.<br><br>Үр дүн: Иргэдийг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажил 16 арга хэмжээ зохион байгуулж, 4902 иргэн, 7891 гэр бүл буюу нийт өрхийн 40,1 хувьд хүрч ажиллалаа. |
| **3.1.3** | **Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1,17 дугаар зүйл, $20^1$ дүгээр зүйлийн $20^1$.1, $20^1$.3, $20^1$.7, $20^1$.9, $20^1$.10 дахь заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.** | |

| | | |
|---|---|---|
| 3.1.3.1. | Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ. | Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/57 дугаар захирамжаар аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай шийдвэр гарч 15 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан.<br><br>Уг захирамжаар сумын Хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн байгуулж, хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг сайжруулахад онцгой анхаарч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосноор Сүхбаатар аймгийн хэмжээнд Хүүхдийн төлөө зөвлөл 100% шинэчлэгдсэн.<br><br>Хүүхдийн төлөө зөвлөлийн анхдугаар хуралдааныг сумдын Засаг дарга нарыг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж 2025 оны ажлын төлөвлөгөөнд 12 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн.<br>Зөвлөлийн хурлаар “Оны онцлох хүүхэд, баг хамт олон”, “Хүүхдэд ээлтэй байгууллага” шалгаруулах болзлыг тус тус хэлэлцэн батласан. Болзлыг албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд хүргэж ажилласнаар шалгаруулалтад материалыг хүлээн авч байна.<br>Хүүхдийн эрх, хамгаалын чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүллээ. Баруун-Урт сумын ЕБС-иудын 1-8 дүгээр ангийн 430 гаруй хүүхдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл, мэдлэг олгох сургалтыг Сүхбаатар аймаг дахь Улсын өмгөөлөгчтэй хамтран зохион байгуулсан.<br>Эрүүл мэндийн газар, АНЭ, Цагдаагийн газартай хамтран “Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё” аяны хүрээнд “Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?” сэдэвт сургалтыг зохион байгуулж 400 өсвөр үеийнхэнийг хамруулсан.<br>Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх “Хүүхэд-Эрхэм хэрэглэгч” аяныг 2025.03.15–2025.05.01-нийг хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгууллаа.<br>Тус аяны хүрээнд нийт 27 байгууллага өөрийн гадаад, дотоод орчны үнэлгээг хийж, гэрийн аюулгүй байдлын үнэлгээг 964 өрхөд хийснээр 3511 иргэн хамрагдаж, 2560 хүүхдийн аюулгүй байдал хангагдсан байна.<br>Аймгийн Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар, Боловсролын газар хамтран 10-18 насны суралцагчдын дунд электрон тамхины хор уршигт шууд болон шууд бусаар уруу татагдах магадлалыг тодорхойлох хор уршгийг олон нийтэд таниулах зорилгоор уг судалгааг хийлээ. Судалгаанд нийт 1421 хүүхэд хамрагдсан. |

| | | |
|---|---|---|
| | | Цагдаагийн газартай хамтран сургууль цэцэрлэгээс 500 метрийн дотор байрлах 35 ААН-д хяналт шалгалт хийж, Электрон тамхи худалдан борлуулахыг бүрэн хориглосон.<br>Өсвөр насны хүүхдүүдийн тамхины хэрэглээ, никотины дасал тамхинд нэрвэгдэх явцыг бууруулах түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Мөнххаан, Дарьганга, Баяндэлгэр, Асгат, Эрдэнэцагаан сумд ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖААР Электрон тамхи болон түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглон хамтарч ажиллаж байна<br>Баруун-Урт сумын ГХУСАЗСЗ, ЕБС- 4 сургууль, ОУ-ын Найрамдал цогцолбортой хамтран “Найз байя” хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулж 1200 хүүхэд, 200 багш, нийгмийн ажилтнууд хамрагдсан.<br>ШШГГ, Прокурорын газартай хамтран Шүүхээс “хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ” авагдсан 10 хүүхдийг сургалт, хүмүүжлийн арга хэмжээнд хамруулж тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>ОБГ, ДБЭХС ТӨК, Баруун-Урт сумын ЗДТГ-тай хамтран “Сар шинэ” “Гэр хорооллын айл өрхийн аюулгүй галлагаа” “Хүүхдийн аюулгүй байдал” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 750 өрхөөр явж эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 35 өрхөд 75 хүүхдэд Хүүхэд гэр бүлийн эрсдлийг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээг хийж, кейс нээн хариу үйлчилгээг үзүүлсэн.<br>Онцгой байдлын газартай хамтран Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Дарьганга, Түмэнцогт, Эрдэнэцагаан, Баруун-Урт сумдын голын орчимд 10 удаагийн эргүүл хяналтын арга хэмжээг зохион байгуулж 1265 хүүхэд, 547 иргэнд санамж, зөвлөмжийг хүргэсэн.<br>Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд ЕБС-ын суралцагч нарт “Хорт зуршил” “Цахим хэрэглээний хор уршиг” “Үе тэнгийн дээрэлхэлт” “Миний биеийн аюулгүйн дүрэм” сэдвүүдээр сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт 2139 хүүхдэд хүрч ажилласан.<br>Ерөнхий боловсролын 4 сургуультай хамтран “Олон улсын хүүхдийн эрхийн конвенцын өдрийг тохиолдуулан” “Эрхээ мэдье-Эрхээ хамгаалъя” арга хэмжээг зохион байгуулж 100 суралцагчийг хамруулсан.<br>Үр дүн: Аймгийн хэмжээнд нийт 12 байгууллагатай хамтран хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нийт 14093 иргэнд хүрч ажилласан байна.<br>Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдааны тоо-1, ХТЗ-н хуралдааны шийдвэрийн тоо - 2 |

| | | |
|---|---|---|
| 3.1.3.2. | Төр, хувийн, хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх | Хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр “Өсвөрийн 100 бөхийн барилдаан”, “Ногоон гэрэл-цагаан шугам”, “Уран жиргээ”, “Өсвөрийн сэргийлэгч” ”Хүн” хүүхдийн бүжгийн наадам, “Хүүхдийн ертөнц” гар зургийн уралдаан, “Өсвөрийн аврагч, “Өсвөрийн сэргийлэгч”, “Замын хөдөлгөөн цагаан толгой” зэрэг аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан 115 удаагийн уралдаан тэмцээнд давхардсан тоогоор 9700 хүүхэд хамрагдсан.<br><br>Дорнод аймагт зохион байгуулагдсан бүсийн аварга шалгаруулах “Өсвөрийн сэргийлэгч”, “Өсвөрийн аврагч” тэмцээнд 3 оролцож, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан.<br><br>Улс, тив, дэлхийн хэмжээний уралдаан тэмцээнд оролцох эрхийг хангасан Нарны хүүхдүүд дуу бүжгийн клубын сурагчдын замын зардалд 1.000.000 сая төгрөг, ЗОК dance бүжгийн хамтлагт 500,000 төгрөг, Аймаг орон нутгийн нэрийг гарган амжилт үзүүлсэн Усан спорт, Жюү жицү зэрэг 2 багт, тус бүр 500.000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.<br><br>Мөн тив дэлхийд амжилт гаргасан сурагч Д.Анударь болон С.Дөлгөөн, Д.Живаамид нарын материалыг бүрдүүлж, Хүүхдийн төлөө санд хүргүүлсэн.<br><br>Үр дүн: Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан 115 удаагийн уралдаан тэмцээнд давхардсан тоогоор 9700 хүүхэд хамрагдсан. |

| | | |
|---|---|---|
| 3.1.3.3. | “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл”-ийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулна. | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөрийн үндэсний сургагч багшийг орон нутгийн хэмжээнд бэлтгэн, хамтран ажилласнаар бага насны хүүхэд, эцэг эх, асрамжлагчдад зөв хооллолтын талаар зөвлөгөө өгөх, хүүхдийн сэтгэлзүйн онцлог, зан үйлийг өөрчлөх дадал олгох чадварт суурилсан оролцооны сургалтаар 19 бүлэг сэдвийн хүрээнд онол, практик хослуулсан хичээлд хамруууллаа.<br>Бага насны хүүхэдтэй ажилтанд зориулан хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд өсгөн бойжуулах, хөгжлийг дэмжих, гэр бүлийн боловсрол олгох байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн гишүүдийг ажлын байранд чадавхижуулах сургалт танхимаар 2 удаа, цахимаар 1 удаа зохион байгуулсан.<br><br>Мөн “Бага насны хүүхдийн цогц хөгжил, сэтгэл зүйн онцлог сэдэвт ” сургалтыг Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэгийн “Хүүхэд хамгааллын баг”-ийн гишүүд, багш нар, эцэг эхийн төлөөлөл 150 хүнийг оролцуулан зохион байгуулсан.<br><br>Дархлаа нь амархан сулардаг, өвчлөмтгий хүүхдүүдийг эрүүлжүүлэх, дархлааг нь дэмжих зорилгоор “Нархан” сувилалд хэвтэн үйлчлүүлсэн 150 хүүхдэд амин дэм дархлаажуулалын багц олгон хамтран ажиллалаа.<br><br>”Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан 56 байгууллагын 2716 эцэг эхэд “Өдөр тутмын хүмүүжлийн эерэг арга” “Хүүхэд хамгааллын бодлого”, “Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо” зэрэг сэдвийн хүрээнд иргэд олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн байна. |
| 3.1.3.4. | Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана | Захиргааны хэм хэмжээний акт нь балбан ёсоор бүртгэгдээгүй, аж ахуй нэгж байгууллагууд бүрэн хэрэгжүүлээгүй одоогоор. Ахмадын сан дээр 14 байгууллага байна. |

| | | |
|---|---|---|
| 3.1.3.5. | Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр тамхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангаж ажиллах | Аймгийн хэмжээнд “Аймгийн хүүхдийн зөвлөл”, “Хүслэн ХОУЗ”, “Эко клуб”, “Өсвөрийн эмч”, “Өсвөрийн сэтгүүлч” зэрэг нийт 73 хүүхдийн оролцооны байгууллагад 1569 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Үүнээс 11 суманд Хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж 247 хүүхдийн гишүүнчлэлтэйгээр ажиллаж байна.<br><br>Хүүхдийн оролцооны байгууллагын гишүүдийг чадавхжуулах сургалт, “Youth power”-байгальд ээлтэй жишиг залуучуудын чуулган, Өсвөрийн сэтгүүлч клубын санаачилгаар- “Хүүхэд хөгжлийн сургалт”, “Хүслэн ХОУЗ-ийн “Халуун сэтгэл” аян, Монголын хүүхдийн майхант чуулган, Сэцэн ханы ирээдүй зүгн бүсийн чуулган, “Сэтгэл бол эрхтэн”, “Би хэлнэ” зэрэг нөлөөллийн арга хэмжээг хамтран зохион байгуулж, 2147 хүүхдийг хамруулсан.<br><br>“Өсвөрийн парламент-2025” арга хэмжээнд ЕБС-ийн сурагчид Б.Норовбүжид, Б.Цэлмэг, С. Номин нар сонгогдон Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан Н.Хонгорзулын хамт оролцсон.<br><br>Газрын зүгээс хүүхдийн оролцооны байгууллагын дунд “Хамтдаа өөрчилье” төслийн уралдааныг 3 дахь жилдээ зохион байгуулж, 11 төсөл ирүүлснээс “Өсвөрийн сэтгүүлч клуб”-ын өв уламжлалаа сэргээн өвлүүлцгээе төсөл шалгарч 1.000.000 төгрөгийн санхүүжилтээ авч, төслөө эхлүүлээд байна.<br><br>Олон улсын хүүхдийн эрхийн хамгаалах өдөрт зориулан орон нутгийн BBS телевизтэй хамтран “Бидний ертөнц” хүүхдийн нэвтрүүлгийн бэлтгэн хүргэсэн ба хөтлөгчөөр Аймгийн хүүхдийн зөвлөлийн гишүүн У.Жаргалан, Б.Ану нар ажилласан. /Хандалтын тоо: 8000/<br><br>Үр дүн: Тайлант хугацаанд нийт 21 арга хэмжээг зохион байгуулж 2147 хүүхдийг хамруулсан. |
| 3.1.3.6. | “Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг | Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан томилогдон ажиллаж байгаатай холбогдуулан мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Үүнд: Хэнтий аймагт зохион байгуулагдсан “Нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах” бүсийн сургалтад 13 нийгмийн ажилтан, аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран Хамтарсан |

| | | |
|---|---|---|
| | илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлнэ | багийн 90 гишүүнийг оролцуулан чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, сургагч багшаар Л.Бадамцэцэг оролцсон. Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газартай хамтран 9 багийн 25 гишүүнийг хамруулан хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”- гээр ажлын байранд чадавхижуулах сургалтыг явуулж, 172 гишүүнийг хамруулан, арга зүйгээр ханган ажилласан нь чухал ач холбогдолтой ажил арга хэмжээ байлаа. Хамтарсан багийн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах, кейс хариу үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, туршлага, мэдээлэл солилцох зорилгоор хамтарсан багийн гишүүдэд сар бүр, шаардлагатай тохиолдолд шуурхай “Кейс хэлэлцүүлэг”-ийг танхимаар 19 удаа, цахимаар 14, нийт 33 удаа зохион байгуулсан. Үр дүн: Хамтарсан багийн гишүүдэд арга зүй өгөх кейс хэлэлцүүлгийг 33 удаа, чадавхжуулах сургалтыг 4 удаа зохион байгуулсан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 475 хүүхдийг хамгааллын үйлчилгээнд хамруулж зохих үйлчилгээг үзүүлсэн. “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд Асгат, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын нутаг дэвсгэрийг дамжин гарсан хээрийн түймэрт өртөж гэр нь шатсан 9 өрхийн 13 хүүхдэд, Халзан, Уулбаян сумдын нутгийг хамарсан цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас аадар бороо, мөндөрт цохигдон, орон гэргүй болсон 21 өрхийн 55 хүүхдэд хуульд заасны дагуу тухайн орон нутгийн Хамтарсан багийн гишүүд газар дээр нь ажиллаж, гамшиг онцгой нөхцөл байдлын үеийн түргэвчилсэн үнэлгээг хийж хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн. Одоогоо эрсдэлийн программд нийт 1382 хүүхэд бүртгэлтэй байна. |
| 3.1.3.7. | Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тусламж, дэмжлэг үзүүлнэ | Монгол улсад Хүүхдийн хөдөлгөөн, байгууллага үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойг “Хүүхэд – хайр – ирээдүй” уриан дор хүүхдийн байгууллагын түүхэн үеийг харуулсан арга хэмжээ, ахмад, дунд, одоо үеийнхний хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр 44 заалт бүхий арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүллээ.Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх арга хэмжээ, “Хүндэтгэлийн шугам жагсаал”, “Баярын хүндэтгэлийн хурал”, “Хүүхэд – Хайр -Ирээдүй” урлагийн тоглолтыг зохион байгуулж, арга хэмжээнд зочид төлөөлөгч, ахмад, дунд үеийн хүүхдийн байгууллагын ажилтан, албан хаагчид, хүүхэд, багачууд төлөөлөл 1250 хүн оролцсон бөгөөд аймгийн Засаг дарга, тамгын газраас 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |

| | | |
|---|---|---|
| **3.1.4.** | **“Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8, 12 дугаар зүйлийн 12.5, 16 дугаар зүйлийн 16.2, 26 дугаар зүйлийн 26.5, 27 дугаар зүйлийн 27.7, 31 дүгээр зүйлийн 31.1, 38 дугаар зүйлийн 38.1.1, 39 дүгээр зүйл, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2.7, 40.4, 40.6, 54 дугаар зүйлийн 54.1.1, 54.1.1, 54.1.3 дах заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.** | |
| 3.1.4.1. | Хүүхэд хамгааллын бодлогыг сурталчлан таниулж салбар бүрд мөрдүүлнэ | Хүүхдийн төлөө зөвлөлийн 03 тоот тогтоолын хэрэгжилтийг хангаж Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 заалтын хангаж ажиллах чиглэлийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгууллага аж ахуй нэгжид хүргэж ажилласан. Нийт 78 байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн судалгаа мэдээллийг шинэчлэн нэгтгэсэн. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан Нийт 7 удаагийн арга хэмжээ зохион байгуулж “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг 49 байгууллага тэмдэглэн өнгөрүүлж, Гэр бүлийн хөгжил хамгааллыг хангаж ажилласан байна. Нийт 56 удаагиийн сургалтаар 2716 ажилтан албан хаагчдад “Гэр бүлийн боловсрол олгох” сургалт нөлөөлийн ажил зохион байгуулан ажилласан. Үр дүн: Нийт 7 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан байна. Хүүхэд хамгааллын бодлоготой 78, Эцэг эхийн зөвлөлтэй 92, хүүхдийн өрөөтэй 72 байгууллага байна |
| 3.1.4.2. | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх | Аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд сум, багийн Хамтарсан багаар дамжуулан дахин үнэлгээ хийхэд 190 хүүхэд эрсдлээс гарсан. Эрсдэлийн программд бүртгэх шаардлагатай 226 хүүхдийг шинээр нэмж бүртгэлжүүлж, тайлант хугацаанд эрсдлийн программд 1382 хүүхэд бүртгэлтэй байна. Үүнээс 922 хүүхдэд гэрээр эргэн хяналт хийж, 806 хүүхдийг хөгжлийн үйлчилгээ болон шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучилж, хүүхэд хамгааллын багцын дэмжлэг олголоо.<br>Мөн хээрийн түймэрт өртөж орон гэр нь шатсан 30 өрхийн 68 хүүхдэд дулаан хувцас, ахуйн хэрэглээний дэмжлэг үзүүлсэн.<br><br>Гэр бүлийн хүчирхийллийн холбон зуучлалаар бүртгэгдэж, дам байдлаар хүчирхийлэлд өртөж болзошгүй 206 хүүхдэд Хамтарсан багаар дамжуулан хамгааллын хариу үйлчилгээнд хамруулсан болно. |

| | | |
|---|---|---|
| | | ГБХНХЯ-ны Сайдын А/203 тушаалын дагуу Асуудал-Шийдэл аян явагдаж байна. Үр дүн:Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхдүүдэд 100 хувь хүрч шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилж ажилласан |
| 3.1.4.3. | Хүүхдийн эрхийн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөр хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх | Аймгийн Засаг даргын 2025.01.21-ний өдрийн А/12 дугаар тушаалаар 13 хүний бүрэлдэхүүнтэй Хууль зүйн хороог шинэчлэн баталж, анхдугаар хуралдааныг зохион байгуулж, тус оны төлөвлөгөөг хэлэлцэн батлаж, гишүүн байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллалаа.<br><br>Жилийн эцсийн байдлаар 8 удаагийн кейс хурлыг зохион байгуулсан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор үйлчилгээ авсан хүүхэд 38, үүнээс хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 8, (Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт 4, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэгт 1, мал хулгайлах гэмт хэрэгт 3), бэлгийн хүчирхийллийн хохирогч 6, зөрчил үйлдсэн 12, гэмт хэргийн сэжигтэн 3, зөрчлийн хохирогч 6, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа 3 хүүхэд тус тус байна.<br><br>Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 8 хүүхдийг хүлээн авч, эцэг эх, асран хамгаалагчидтай нь хариуцлагын гэрээг байгуулж, хүүхэд тус бүрийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг батлуулж, 10-36 цагийн сургалтад бүрэн хамруулж, тайланг ШШГГ-т сар бүр хүргүүлж байна.<br><br>Хорооны үйлчилгээнд байгаа кейсийн үйлчилгээг ангилж үзвэл: Хууль ёсны төлөөлөгчөөр 6, боловсролын үйлчилгээнд холбон зуучилсан 32, эрүүл мэндийн үйлчилгээнд 30, өмгөөллийн үйлчилгээнд 5, сэтгэл зүйн үйлчилгээнд 38 хүүхдийг хамруулсан.<br><br>Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, 1 үйлчлүүлэгчийн сэтгэцэд учруулсан гэм хорын хохиролд 3,293,000 төгрөгийн хохирлыг тогтоолгосон.<br><br>Хохирогч, холбогдогч хүүхдүүдийг хөгжүүлэх, олон нийтийн арга хэмжээнд хамруулах зорилгоор БХ-ийн хохирогч 2 хүүхдийг “Майхант зуслан”-гийн хөтөлбөрт, ХЧАА авагдсан 5 хүүхдийг “Хүүхдийн чуулган”, “Ханан-3”, “Unitel hub” зэрэг хөгжлийн үйлчилгээнд хамруулсан. |

| | | |
|---|---|---|
| | | Нөхцөл байдлын үнэлгээг 35 удаа хийж, хорооны үйлчилгээнд бүртгэгдсэн хүүхдүүдэд 100 хувь хариу үйлчилгээ үзүүлсэн. |
| 3.1.4.4. | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас,эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавина | 2025 онд аймгийн хэмжээнд нийт 47 уралдаан зохион байгуулагдаж, 1815 уралдаанч хүүхэд мэдээллийн санд 100% бүртгэгдсэн байна. Нийт уралдааныг ангилж үзвэл:<br>Үндэсний их баяр наадам-11<br>Бүсийн чанартай уралдаан-7<br>Орон нутгийн шинжтэй-22<br>Бичил уралдаан-7 зохион байгуулагдсан байна.<br>Аймгийн Засаг даргын 2025 оны А/166 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Жавхлант шарга” МСУХ зохион байгуулсан “Аймгийн аварга хүлэг шалгаруулах” 7 насны хурдан морины уралдаан, Дарьганга суманд зохион байгуулагдсан Өмнөд бүсийн “Монгол морины хаврын уралдаан”, Халзан суманд зохион байгуулагдсан бага 3 насны уралдаан, тэмдэглэлт ой нь тохиосон 7 сумын баяр наадамд ХЭУБ, мэргэжилтнүүд уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хууль, стандартыг таниулж, хяналт тавих чиглэлээр зохион байгуулагч талтай болон тухайн орон нутгийн салбар комисстой хамтран ажилласан ба сум орон нутагт зохион байгуулагдсан бусад уралдаанд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хамтарсан багийн бүрэлдэхүүн 100% хяналтыг тавьж ажиллалаа.<br><br>Уралдааны замд нийт 29 уралдаанч хүүхэд мориноос унасан ба гэмтэл бэртэл авсан 7 хүүхэд бүртгэгдэж, гэнэтийн ослын даатгалын сангаас 22,458,000 төгрөгийн нөхөн олговор олгогдсон байна.<br><br>Үр дүн: Тайлант хугацаанд аймаг, сумын Засаг даргын захирамжтай 47 уралдаанд нийт 1815 уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. |

| | | |
|---|---|---|
| 3.1.4.5. | Гамшиг онцгой байдлын үе, ган, зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэтгэж гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд Асгат, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын нутаг дэвсгэрийг дамжин гарсан хээрийн түймэрт өртөж гэр нь шатсан 9 өрхийн 13 хүүхдэд дулаан хувцас, ахуйн хэрэглээний дэмжлэг үзүүлсэн.<br><br>Мөн Халзан, Уулбаян сумдын нутгийг хамарсан цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас гэр нь аадар бороо, мөндөрт цохигдон орон гэргүй болсон 21 өрхийн 55 хүүхдэд хуульд заасны дагуу тухайн орон нутгийн Хамтарсан багийн гишүүд газар дээр нь ажиллаж гамшиг онцгой нөхцөл байдлын үеийн түргэвчилсэн үнэлгээг хийж хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн.<br><br>Гамшигт өртсөн иргэдэд аймгийн болон Улсын онцгой комисс, сумын Засаг даргын тамгын газар хамтран шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг үзүүлсэн. Аймгийн Онцгой байдлын газраас Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн төлөвлөгөөт сургалтад болон Бэлэн байдлын дохиогоор анги бүрэлдэхүүн бүрэн хамрагдсан.<br><br>Үр дүн: нийт-30 өрх, 68 хүүхэд / |
| 3.1.4.6. | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдао, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчинд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай завсар үйлчилгээг хийх, | ОБГ, ДБЭХС ТӨК-тай хамтран "Гэр хорооллын аюулгүй галлагаа, цахилгааны аюулгүй байдал арга хэмжээ болон "Хэрсүү гурвалжин" аяныг аймгийн төвийн бүх багуудад, Цагдаагийн газар, Баруун-Урт сумын ЗДТГ-тай хамтран "Тоглоомын талбай-Хүүхдийн аюулгүй байдал" эргүүл хяналт, "Тоглоомын талбай- Эргүүл хяналт"-ын арга хэмжээг 2 удаа зохион байгуулан ажилласан.<br>Хяналт шалгалтыг Баруун-Урт сумын төвийн багийн 15 нэгжид хүүхдийн тоглоомын талбайн Ерөнхий шаардлага MNS6751:2019 Стандартын 7 болон А хавсралтын хүрээнд явуулсан ба хяналт шалгалтын явцад нийтлэг 10 гаруй зөрчил илэрсэн бөгөөд хяналт шалгалтын үр дүнг холбогдох байгуулагад танилцуулан зөрчлийг арилгуулахаар зөвлөгөө өгч ажилласан.<br>- Томчуудын зохисгүй үйлдэл /архидалт, эвдэж сүйтгэх үйлдэл/<br>- Харанхуй гудамж, золбин нохой |

| | | |
|---|---|---|
| | анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх | - Талбайн орчинд анхааруулах, хориглох тэмдэг, онцгой байдлын үед залгах дугаарыг харагдах орчинд байрлалгүй<br>- Тоглоомын талбайн хориглох тэмдэг<br>- Эвдэрч гэмтсэн шон, хашлага, сандал, тоглоом, гэрэлтүүлэг, камергүй<br>- Ил задгай цахилгааны утас<br>- Хог хаягдал ил задгай хаясан зэрэг зөрчил түгээмэл байна. |
| 3.1.4.7. | Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна | Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд Эрдэнэцагаан суманд “Багачуудын ордон” хүүхэд харах үйлчилгээний төв ажиллаж байгаа бөгөөд тус төвд 15 хүүхэд, 3 хүүхэд харагчтайгаар үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсан.<br>Хүүхэд харах үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж газар дээр нь 5 заалт бүхий зөвлөгөөг өгч ажилласан.<br><br>Аймгийн ИТХ-ын даргын 2025.05.05-ны өдрийн А/31 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон удирдамжийн дагуу ажилласан.<br>Аймгийн хэмжээнд нийт 18 сүм, хийд ажиллаж байгаагаас албан ёсны зөвшөөрөлтэй 14 хийд ажиллаж байна. Христийн 1 сүм байна. Зөвшөөрөлгүй сүм, хийд 4 ажиллаж байна.<br>Баруун-Урт сумын Эрдэнэмандал хийдийн дэргэд үйл ажиллагаа явуулж буй “Баян-Эрхэт” шашны сургуульд нийт 12 ламхай хүүхэд бүртгэлтэй, тогтмол шавилан сууж хичээллэдэг. Сургалт хариуцсан багшид хүүхэд хамгааллалтай холбоотой асуудлаар газар дээр нь хүүхдийн орчны аюулгүй байдал, үе тэнгийн дээрэлхэлт, хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөөтэй ажиллах зэрэг чиглэлээр зөвлөсөн.<br>Аймгийн Засаг даргын 2025.05.23-ны өдрийн А/257 дугаартай “Хүүхэд хэрэглэгч” нэгдсэн арга хэмжээний ажлын хэсэг байгуулах тухай шийдвэрийн дагуу 29 супермаркет хүнсний дэлгүүр, 8 худалдааны бөөний төв, 13 ресторан, цайны газар, 4 халуун усны газруудын үйл ажиллагаанд зөвлөн туслах, хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан. Уг арга хэмжээний хүрээнд хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлж ажлын хэсгийн зүгээс Хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид мэдэгдлийг хүргүүлж, аюулгүй байдлыг хангаж ажилласан. |
| **3.2.** | **Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль,Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнии тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;** | |

| | | |
|---|---|---|
| 3.2.1. | Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.6, 33 дугаар зүйлийн 33.1, 36 дугаар зүйлийн 36.1.3, 159 дүгээр зүйлийн 159.2 заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: | 2025-2026 оны нийгмийн түншлэлийн 3-н талт хамтын хэлэлцээрт ХХҮГазрын удирдлага төлөөлөл болон ажиллаж байна. Тус онд 7 байгууллагын хамтын гэрээнд хяналт хийж баталгаажуулсан. |
| 3.2.1.1 | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | Хөдөлмөрийн тухай хууль,дүрэм, журмын талаар аж ахуй нэгж байгууллагын ажилтнууд, малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт 650 иргэнд мэдээлэл, сургалт хийсэн. Хүсэлт ирүүлсэн 150 байгууллагын хөдөлмөрийн гэрээ, тушаал шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам боловсруулахад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.<br><br>Биелэлт 100% |
| 3.2.1.2 | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч,ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион | “Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлж Баруун-Урт сумын бизнес эрхлэгч 120 ажил олгогчид хөтөлбөрийн талаар сургалт зохион байгуулан зөвлөгөө өгч зөвлөх үйлчилгээ авах хүсэлт гаргасан **17** аж ахуйн нэгжид хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээг үзүүлж зөвлөх үйлчилгээний зардалд 60,0 сая төгрөг зарцуулсан.<br><br>Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| | байгуулахад дэмжпэг үзүүлнэ. | |
| 3.2.1.3 | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр. хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах. | Хөдөлмөрийн маргаан зохицуулах асуудлаар 5 аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлэл өгч зөвлөмж хүргүүлсэн.<br><br>Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| 3.2.1.4 | Аймаг. сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих. хэрэгжилтийг зохион байгуулахад санаачлагатай ажиллах; | 2025-2026 оны аймгийн хамтын хэлэлцээрийн дагуу:<br><br>1. Ажил олгогч бизнесийн зөвлөгөөн - Хөдөлмөрийн яармаг зохион байгуулж 50 аж ахуй нэгж, 70 иргэн хамрагдаж ажил зуучлах үйлчилгээг хийсэн.<br>2. Хөдөлмөрийн аюулгүй байдал Эрүүл ахуйн сарын аяны хүрээнд:<br><br>● Нээлтийн үйл ажиллагаанд 70 аж ахуйн нэгжийн 150 ажилтан, ажил олгогчид зөвлөгөө мэдээлэл<br>● Цайрт минерал ХХК, ДБЭХС ТӨХК-ний Сүхбаатар ЦТСтанцийн туршлага судлах арга хэмжээнд 5 байгууллагын 50 ажилтан албан хаагчдыг хамруулсан.<br>● Хөдөлмөрийн тухай хууль, дүрэм, журмын талаар 15 удаагийн сургалт зохион байгуулж 150 аж ахуй нэгжийн 600 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>● 7 албан байгууллага, аж ахуйн нэгжүүдээс ирсэн хамтын гэрээг хянаж баталгаажуулсан.<br><br>● Хөдөлмөрийн эрхийн маргаан 4 иргэнээс ирсэн Баруун-Урт сумын хөдөлмөрийн эрхийн маргаан таслах гурван талт хороогоор хэлэлцэн маргааныг шийдвэрлэсэн.<br><br>● Энэ онд 25 ба түүнээс дээш ажиллагсадтай 38 ААН байгууллагаас судалгаа авч нэгтгэн мэдээллийн сан үүсгэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй 5 байгууллагын 17,160.0 мянган төгрөг ХЭДСанд төвлөрүүлсэн.<br><br>Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| 3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ’ | | |
| 3.2.2.1 | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | “Хүүхэд бүрт сүү” хөтөлбөр хэрэгжиж, орон нутагтаа сүүний үйлдвэр ажилуулж, ажлын байр шинээр бий болгож орон нутгийн сургуулийн хүүхдүүдийг шинэ сүүгээр хангаж ажиллаж байна. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 123 иргэний үйлдвэрлэсэн 200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг Баруун-Урт, Түмэнцогт сумын борлуулалтын цэгээр дамжуулан худалдаалж 34,2 сая төгрөгийн борлуулалт хийсэн.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд нийт 120 зорилтот бүлгийн иргэдийг хамруулж, иргэд өрхийн үйлдвэрлэл эрхэлж, өрхийн орлогыг нэмэгдүүлсэн. Үүнд:<br>30 иргэнийг танхимын сургалтад<br>90 иргэнийг мод тарих арга хэмжээнд хамруулсан. |
| 3.2.2.2. | Орон нутгийн ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын статистик мэдээлэл, бүртгэлтэй ажилгүй, ажлын байрны захиалга зэрэг захиргааны мэдээний чанарыг сайжруулах, тогтмол шинэчлэх; | Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан Ejob системд 1005 шинэ ажлын байрны мэдээлэл бүртгэсэн. Үүнээс: 538 эмэгтэй, 467 эрэгтэй байна.Нийт ажлын байрны 53,7% нь байнгын ажлын байр байна. Тус онд 444 ААН байгууллага, иргэнээс 1585 ажлын байрны захиалгын дагуу 922 иргэнийг ажилд зуучилсан. Үүнээс 479 нь байнгын ажлын байр 431 түр ажлын байр, цагийн ажилд 12, Эрэгтэй 382, Эмэгтэй 540<br><br>Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| 3.2.2.3. | Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг нийт 3890 өрхөөс судалгаа авахаас:<br><br>1.Бүрэн судалгаа 1267<br><br>2.Хариулт өгөх хүн байгаагүй 4<br><br>3.Гэрийнхэн түр хугацаагаар эзгүй 26<br><br>4.Хойшлуулсан 488<br><br>5. Татгалзсан 1376<br><br>6.Өрхийг олоогүй 729 байна.<br>Биелэлт 100% |
| 3.2.2.4. | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдпыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн байдлаар нарийвчлан судлан тодорхойлж, хүний нөөцийн оновчтой төлөвлөлт, хуваарилалтын зохицуулалтыг хийж ажиллах; | Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа 150 аж ахуй нэгж байгууллагаас ажиллах хүчний хэрэгцээний судалгаа авахад шинээр бий болсон ажлын байр 44, сул чөлөөтэй ажлын байр 77 байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээний судалгааг аймгийн хэмжээнд 6247 иргэнээс маягтын дагуу авахад:<br><br>● Ажил идэвхитэй хайж байгаа 2019<br>● АМЧБО зөвлөгөөнд хамрагдах хүсэлтэй 1359<br>● Санхүүгийн дэмжлэгт хамрагдах 1669<br><br>● Сургалтад хамрагдах 1200 иргэн байна.<br><br>Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| 3.3.3.2 | Хөгжпийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна; | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар нийт 5 удаа 180 хүнд сургалт мэдээлэл өгсөн.<br>Биелэлт 100% |
| 3.3.3.3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл сургалтыг зохион байгуулах хөгжлийн бэрхшээлтэй үндэсний сургагч багш бэлтгэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, орон нутгийн эмч, ажилтнуудыг энэ чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулна; | 1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн чиглэлээр шинээр гарсан журам, тушаал шийдвэрүүдийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад таниулах ажлыг цаг тухайд нь зохион байгуулдаг.<br>2. Жил бүр анхан шатны эрүүл мэндийн төвийн эх хүүхэд хариуцсан эмч, сувилагч нарыг чадавхжуулах зорилгоор ЭМГ-аас сургалтын хөтөлбөр боловсруулан АНЭ-тэй хамтран ажлын байрны онол дадлага хосолсон богино хугацааны сургалтыг зохион байгуулж байна. 2025 онд өрх, сумын 7 их эмч, 11 сувилагчыг АНЭ-ийн төрөх, хүүхдийн тасагт 7 хоногийн сургалтад хамруулсан.<br>3. Сонсголын бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахад хүртээмжтэй байх боломжийг хангах зорилгоор Аймгийн засаг даргын тамгын газар, сонсголын бэрхшээлтэй иргэдийн албан ёсны төлөөлөл, Эрүүл мэндийн газар хамтран зохион байгуулсан Монгол дохионы хэлний анхан шатны 3 өдрийн сургалтыг Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгууллаа. Сургалтад 40 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. |

| | | |
|---|---|---|
| | | 4. Нөхөн үржихүйн насны хөгжлийн бэрхшээлтэй 198 эмэгтэйд ганцаарчилсан сургалтыг өгсөн.<br><br>5. 2025 онд АНЭ-т сонсголын бэрхшээлтэй 1 эмэгтэй төрсөн. Жирэмслэлтийн болон төрсний дараах хугацаанд зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Цахим болон танхимын сургалтад 60 хүнийг хамруулсан.<br><br>6. Дэмжих бүлгийн ээжүүдийн уулзалт сургалтыг 1 удаа зохион байгуулсан.<br><br>7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ээжүүдийн бүлгийн сургалтыг 1 удаа зохион байгуулсан. Нийт бүлгийн сургалтад хамрагдсан хүний тоо: 18<br><br>8.Явуулын амбулаторийн 8-12 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт Хөгжлийн бэрхшээлтэй 403 хүнийг хамруулсан.<br>9.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 402 дугаар тогтоолоор батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журамын дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд зохион байгуулсан. Уг үзлэгт 279 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 500 эцэг эх, асран хамгаалагчаас 216 /43,2%/ асран хамгаалагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөлтэй гарсан иргэдэд дараагийн шатны арга хэмжээг авч ажилласан.<br>10.“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг сурталчилан таниулах, тэгш оролцоог хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх “ТЭГШ БОЛОМЖИЙГ ХАМТДАА” өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгөөр:<br>- ЭХО үзлэг-25 хүнд<br>- Нүдний үзлэг-19 хүнд<br>-Элэгний В,С вирусын илрүүлэг түргэвчилсэн шинжилгээ-52 хүнд<br>-БЗДХ, ХДХВ-ын илрүүлэг түргэвчилсэн шинжилгээ- 52 хүнд хийсэн.Мөн Эрүүл мэндийн сургалт мэдээллийг 86 хүнд өгч , витаминжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулсан байна. |

| | | |
|---|---|---|
| 3.3.3.4 | Байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн хөгжпийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх Дэмжих төвийг байгуулан ажиллуулна; | Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн дэмжлэгийн төв байгуулах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, эцэг эх нийт 50 хүнийг “Итгэл сэтгэлийн ертөнц” ТББ-ын төлөөлөгч болон ХБХүүхэдтэй эцэг эхчүүдийг Улаанбаатар хотын Эрхэм нандин сувд ТББайгууллагын дэргэдэх “Эрхэм асралт Илч” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн дэмжлэгийн төвийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлуулсан. Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд “Үйлст их” НҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, нийт 160 хүнд сэргээн засах үйлчилгээг үзүүлсэн.<br>Биелэлт 30% |
| 3.3.3.5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааплын комиссын дүрмийн 1.10, 2.5, 2.7, 3.3.7, 3.3.8, 6.1-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана; | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааплын комиссын дүрмийн дагуу салбар комиссыг байгуулж үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Мөн комиссын гишүүдийн ажлыг жил бүр сонсож цаашид хэрэгжүүлэх ажлыг дэмжин ажиллаж байна. Биелэлт 100% |
| 3.3.3.6 | Салбар комиссын үйл ажилагааны зардлыг орон нутгийн төсөвт тусгах, албан байраар болон гишүүдийн ажиллах нөхцөлийг хангаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хүүхдийн хөгжлийн хоцрогдол бэрхшээлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах зэрэг шаардлагатай дэмжлэг,туслалцааг үзүүлнэ; | Салбар комиссын үйл ажиллагааг дэмжиж комьютер, принтерээр хангасан. Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, Улсын гуравдугаар эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн 19 эмчийн үзлэг оношилгоонд хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхдийг асран хамгаалагчийн хамтаар нэгдсэн унаагаар үйлчилж байр хоолны зардал 5.9 сая төгрөгийг Аймгийн болон сумдын ЗДТГазартай хамтран шийдвэрлэж хамруулсан.<br>Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| 3.3.3.7 | Хөгжпийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай тесвийг шийдвзрлзн дэмжлэг үзүүлж ажиллана; | Аймгийн ИТХурлын шийдвэрээр 10 сая төгрөг батлуулж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Биелэлт 100% |
| 3.3.3.8 | Орон нутгийн гамшгаас хамгаапах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжпийн бэрхшээптэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед болон гамшгийн дараа хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн хэлбэрт нийцсэн арга хэмжээг төлөвпөн ажиллана. Ингэхдээ гамшиг ослын үеийн дуудлага, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд ялангуяа сонсголын болон харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх, хүртээмжгэй хоргодох байрын тоог нэмэгдүүлэх зэрэгт онцгойлон анхаарч ажиллана; | Гамшгаас хамгаалах боловсролыг бүх шатанд хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2025 оны А/406 дугаар тушаалыг хэрэжилтйг ханган аймгийн Онцгой байдлын газраас аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, “Тусч хүч” ТББайгуулагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт болзошгүй гал түймэр, гамшиг ослын талаарх мэдлэг ойлголт олгох, гамшгийн үед өөртөө болон бусдад туслах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх дадал төлөвшүүлэх зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 2-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” сургалтын хөтөлбөрийн хүрээнд сургалт зохион байгуулав. Тус сургалтын хөтөлбөрийн хүрээнд Онцгой байдлын газар 7 хоногийн Мягмар, Пүрэв гарагт сургалтыг зохион байгуулж<br><br>Гамшиг ослын тухай ойлголт<br>Гал түймрийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ,<br>Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ<br>Үер усны ослоос урьдчилан сэргийлэх<br>Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл ашиглах заавар<br>Бэлэн байлын багц сэдвүүдээр танхимын сургалтыг зохион байгуулсан. Мөн What3words /3 үгт хаяг/ аппликейшныг таницуулан гар утсанд нь суулган ашиглах зааврын таницуулсан. Энэ аппликейшныг ашиглан гамшиг ослын үед өөрийн байгаа байршилаа шууд тодорхойлох, утсаар мэдэгдэх, мессэж илгээх боломжтой юм. Сургалтыг 7 хоногт 1-2 удаагийн давтамжтай зохион |

| | | |
|---|---|---|
| | | байгуулж нийт 16 удаагийн сургалтаар 149 иргэнийг хамруулсан. Сургалт явуулсан баг: Нийгмийн ажилтан- Л.Эрдэнэцэцэг ХГБЗХГазрын мэргэжилтэн Багш-Ц.Олзод- Насан туршийн боловсролын байгууллагын багш Сүхбаатар аймгийн ОБГ мэргэжилтэн, дэслэгч Ю.Цэрэндулам Сэтгэлзүйч - Ц.Мөнхтунгалаг “Тусч Хүч” ТББ-ын сэтгэл засалч эмч нар Хууль эрхзүйн мэдээллийн сургалтыг “Тусч Хүч” ТББ-ын тэргүүн С.Эрдэнэбат нар баг болон хамтран ажилласан. Сургалтад хамрагдсан иргэдэд хувийн хэрэг нээж ирцийг өдөр бүр тэмдэглэн баталгаажуулсан. Үйлчлүүлэгч нарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд гэсэн 2 бүлэгт хуваан сэтгэлзүйн тусламжийг бүлгээр үзүүлж Стресс менежмент сэдвээр сургалт хийсэн.<br>Нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийж үйлчлүүлэгч нарын хүсэл сонирхолд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 ээжийг ГБХЗХГазрын хөгжлийн хөтөлбөрт холбон зуучилсан. Сэтгэл ханамжийн судалгааг хүн бүрээс авч хувийн хэрэгт хавсарсан. Сүхбаатар аймгийн хэмжээнд 68 хорогдох байртай. |
| 3.3.3.9 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг энэ чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ; | "Тусч хүч" ТББ -тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эх, эцэг, асран хамгаалагч нийт 160 иргэнд сэтгэлзүй, гар урлал, хуулийн талаарх зөвлөгөө мэдээлэл өгсөн.<br><br>Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| 3.3.3.10 | Засгийн газрын 2022 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ыг хэрэгжүүлж, ХӨГЖЛИЙН бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авсан ажил олгогчийг дэмжих, төлбөрийг хөнгөлөх,чөлөөлөх арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэшсэн төрийн бус байгууллагуудаар аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөгөө өгөх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг гүйцэтгүүлнэ; | Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 8 иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг Баруун-Урт, Түмэнцогт сумын борлуулалтын цэгээр дамжуулан худалдаалж байна. Мөн Эм-Эл-Цахиурт Овоо ХХК хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн, Хунт-Өгөөж КК хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнтэй тус тус гэрээ байгуулж мах, бээлийн худалдан авч байна. Биелэлт 100% |
| 3.3.3.11 | Нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр,төлөвлөгөөг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцэж байгаа эсэхийг судлан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна; | “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт, нутгийн удирдлагын оролцоо үндэсний зөвөлгөөн”-д аймгийн удирдлагууд, салбарын холбогдох мэргэжилтнүүд нийт 4 хүн хамрагдаж зөвлөгөөнөөр тавигдсан мэдээллийг орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулсан. ●“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалт”-г 4 хоногийн хугацаанд зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн 30 хүн хамрагдсан. ●Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдрийг угтан төрийн болон төрийн бус байгууллагууд нээлттэй өдөрлөг зохион байгууллаа. Үүнд 100 гаруй иргэд хамрагдсан. Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| 3.3.3.12 | Цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, 2- оос доошгүй мэргэжлийн дохионы орчуулагчийг бэлтгэн ажиллуулна; | Харааны бэрхшээлтэй 15 иргэнд брайль үсгийн сургалтыг 14 хоногийн хугацаатай “Ариун бичээс нийгэмлэг” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан.<br>Биелэлт 100% |
| 3.3.3.13 | Жилд 3-аас доошгүй төрийн үйлчилгээний байгууллагын гадна,дотор талын хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, саадгүй болгоно; | “Хүүхэд хэрэглэгч” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн засаг даргын А/257 захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээний байгууллагын үйлчилгээг ээлтэй болгох зорилгын хүрээнд Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны байгууллага, үйлчилгээний төвүүдийн орж гарц, дотоод орчинд үнэлгээ хийж сайжруулах талаар зөвлөмж өгсөн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу 2025 онд “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс”-н бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн оролцоог хангаж Шинэ тэмүүлэл хотхон, Цэлмэг аппартмент, Мөнххаан сумын 24 айлын орон сууцны барилга Прокурорын шинэ оффис, Баян шарга хотхоны 3 дугаар ээлж, Асгат сумын Ахуйн үйлчилгээний төвийн барилга, Соёл амралтын хүрээлэн, Худалдааны гудамжны тохижилт, Ургах наран хорооллын авто зам, Усан спортын төвийн зүүн талын тохижилт, Онгон сумын наадмын талбай, НДХ зүүн уулзварын авто зам, Боловсрол хорооллын хойд талын авто зам, Эрдэнэцагаан сумын цэцэрлэгт хүрээлэн, Наран сумын спорт заалын засвар, Асгат сумын авто зам, Наран сумын авто зам, Халзан сумын эрүүл мэндийн төв зэрэг 18 барилга, байгууламж, дэд бүтцэд хүртээмжийн үнэлгээ хийв.<br>Биелэлт 100% |

| | | |
|---|---|---|
| 3.3.3.14 | Хөгжпийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Хүүхдийн төлөө зөвлөл, Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, Хөгжпийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүүхэд, залуучууд,ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагыг дэмжиж бодит оролцоог ханган, салбар дундын уялдаа холбоог сайжруулна. | Салбар комиссын үйл ажиллагааг дэмжиж комьютер, принтерээр хангасан. Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, Улсын гуравдугаар эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн 19 эмчийн үзлэг оношилгоонд хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхдийг асран хамгаалагчийн хамтаар нэгдсэн унаагаар үйлчилж байр хоолны зардал 5.9 сая төгрөгийг Аймгийн болон сумдын ЗДТГазартай хамтран шийдвэрлэж хамруулсан.<br><br>Биелэлт 100% |
| 3.3.4. | **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйл хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.** | |

| | | |
|---|---|---|
| 3.3.4.1 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна | Үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, үр хойчдоо өвлүүлэн үлдээх, спортлог гэр бүлийг дэмжих, ахмадын хөгжил, оролцоо, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, харваачдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Нумт харвааны аймгийн аварга гэр бүл" шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, уг тэмцээнд 13 сумын 24 гэр бүл, 28 хос нийт 100 гаруй харваач авхаалж самбаа, ур чадвар, цэц мэргэнээ сорин оролцож төрөл тус бүрд шилдгүүдийг шалгаруулан алдаршууллаа. Тус тэмцээнд 13 сумын 24 гэр бүл, 28 хос нийт 100 гаруй харваач оролцсон. Аймгийн ахмадуудын удирдлагын зөвлөгөөнд "Ахмад настны тухай" хуулийн шинэчилсэн найруулгаар сургалт зохион байгуулж 660 ахмад оролцсон. Хойч үедээ үнэт ёс заншил, өв уламжлалаа өвлүүлэн үлдээх зорилгоор "Гэрлэлтийн батлах гардуулах" хүндэтгэлийн арга хэмжээнд 60 жил хамт амьдарсан гэр бүлийн "Очир Эрдэнийн хурим"-ын үйл ажиллагааг зохион байгууллаа.<br>Байгууллгын 100 жилийн хүрээнд Хүүхдийн байгууллагад ажиллаж байсан 80 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, Төрийн одон медалиар 3 ахмад, Монголын залуучуудын холбооны "Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч" медалиар 2 ахмад ажилтныг шагнаж урамшуулсан. Мөн хүүхдийн байгууллагад хамгийн олон жил ажилласан 3 ахмадын хөрөг нэвтрүүлгийг бэлтгэж байгуулагын пэйж хуудас, орон нутгийн телевизээр нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлсэн.Үр дүн: Ахмад настныг дэмжих чиглэлээр 3 арга хэмжээнд 852 орчим ахмадыг оролцууллаа. Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе" уриан доорх аяны хүрээнд иргэд олон нийт болон төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх сургалтыг байгууллага бүр дээр хийж, аянд нэгдэн олон нийт болон бусад байгууллагаг уриалсан шторк пост хийж байгууллагын цахим хуудсуудад тавьж ажилласан. Мөн технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлд нэгдэцгээе аяны хүрээнд холбогдох газруудад албан бичгээр мэдээлэл зөвлөгөө өгч, 12 байгууллага аянд нэгдэж, 3 газар ТАҮБЖСХ-ийн сургалтыг албан хаагчид зохион байгуулан ажилласан. "Жендэр ба хөгжил" нэгдсэн сургалтыг хийж |

| | | |
|---|---|---|
| | | сургалтад удирдлага, төрийн байгууллагуудын удирдлага, Баруун-Урт сумын ИТХ-ын дарга, гишүүд, багийн засаг дарга нар, холбогдох мэргэжилтнүүд, ЗХ-ний 338-р анги болон 065-р ангийн 086-р салбарын алба хаагчид, аймгийн Цагдаагийн хэлтсийн алба хаагчид нийт 120 гаруй (эрэгтэй 84, эмэгтэй 39) хүнийг хамруулсан байна. НҮБ-ийн хүнс хөдөө аж ахуйн албатай хамтран "Мал аж ахуй ба жендэр" сургалтад 30 албан хаагчийг хамруулж, мал аж ахуй эрхэлдэг иргэдээс судалгаа авч мэдээлэл өгсөн бөгөөд 9 сарын байдлаар 150 албан хаагчдад жендэрийн талаарх ойлголт мэдээллийг өгч ажилласан байна. Жендэрт суурилсан хүчирхийллийн урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах чиглэлээр шинээр буцалтгүй тусламжийн төслийг АХБ-аас боловсруулж, АХС болон JFPR-аас санхүүжүүлж байгаа бөгөөд хүчирхийллийг гарахаас нь өмнө арилгах цогц арга барилыг авч ажиллах зорилготой төслийн хүрээнд ЕБС, МСҮТ-ийн дотуур байрыг засах, барих тухайн орон нутагт ЖСХ-аас урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг сайжруулах ажлыг цогцоор нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төслийг хэрэгжүүлэх багийн гишүүдийг засаг дарга болон холбогдох салбарын удирдлагуудтай уулзуулж, холбогдох судалгаа мэдээллийг гаргаж, жендэрийн сарын аяны постер мэдээллийг олон нийтэд түгээн ажилласан. |
| 3.3.5. | **Ахмад настны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана** | |
| 3.3.5.1. | Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид сургалт, сурталчилгаа хийх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон | Ахмад настны тухай хуулийн шинэчлэл, танилцуулгыг ахмадын хороо, сумдын салбар хороонд нийт 24 удаа мэдээлэл өгсөн. |

| | | |
|---|---|---|
| | нийтэд чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулах | |
| 3.3.5.2. | Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөвт байгууллага болон ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих | Ахмадын сан, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлэн ажилладаг байгуулагуудын судалгаа мэдээллийг авч нэгтгэхэд 26 байгууллага судалгааны мэдээллээ ирүүлснээс 14 байгууллага буюу 54% нь ахмадын сантай, 10 байгууллага тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Судалгааны нэгтгэлийг гаргасны дараагаар холбогдох газруудад албан бчигээр мэдээлэл өгч ахмадын сан байгуулан ажилуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анхааран ажиллахыг сануулсан албан тоот илгээсэн. |
| 3.3.5.3. | Ахмад настны эрүүл, идэвхитэй насжилтыг дэмжих, асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор Ахмадын ордон, өргөө байгуулах, ашиглалт, засварын зардал, үйл ажиллагааны төсвийг ИТХ-аар шийдвэрлүүлэх, Ахмадын ордон, өргөөний үйлчилгээнд ахмад настанг хүртээмжтэй, тэгш хамруулан ажиллах | Ахмад настны хөгжил оролцоог дэмжих, тэдний үйл ажиллагаанд зарцуулах 147,899.1 төгрөгийг ИТХ-аар батлуулан үйл ажиллагаа болон ахмад настнуудын хөгжил оролцоог дэмжиж ажилласан. Мөн аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө болон засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан тодорхой ажлуудыг дэмжин ажиллаж засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнд: Уянгаар хөглөгдсөн ахмадууд 2025, Тойром нут шагайн харваа, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “ АХМАД 2025 ” СПОРТЫН ОЛОН ТӨРӨЛТ 7-Р НААДАМ гэх мэт арга хэмжээнүүдэд дэмжлэг үзүүлэж хөгжил оролцоог ханган ажилласан.Ахмадын асаргааны хувилбарт үйлчилгээнд 172 хүн хамрагдаж, 37564.0 мянган төгрөгийг шилжүүлсэн. Ахмадын насжилтыг дэмжих төвийн үйлчилгээнд 2281 ахмад хамрагдаж, 50944.0 мянган төгрөгийг шилжүүлсэн. Биелэлт 100% |
| 3.5.3.4. | Ахмад настны идэвхитэй насжилтыг дэмжих төвийг байгуулж ажиллуулах, Ахмадын ордон, өргөөний үйл ажиллагааг сайжруулж, идэвхитэй насжилтыг дэмжих үйлчилгээнд шилжүүлэх | Ахмадын асаргааны хувилбарт үйлчилгээнд 172 хүн хамрагдаж, 37564.0 мянган төгрөгийг шилжүүлсэн. Ахмадын насжилтыг дэмжих төвийн үйлчилгээнд 2281 ахмад хамрагдаж, 50944.0 мянган төгрөгийг шилжүүлсэн. |

| | | |
|---|---|---|
| 3.3.5.5. | Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах | Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээг давхардсан тоогоор 3083 ахмадад хийсэн. |
| 3.3.5.6. | Ахмад настны цогц үнэлгээ хийж, цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтыг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих | Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулж төлөвлөгөөг баталж ажилласан.Ахмадын асаргааны хувилбарт үйлчилгээнд 172 хүн хамрагдаж 37564.0 мянган төгрөг зарцуулсан. Ахмадын насжилтыг дэмжих төвийн үйлчилгээнд 2281 ахмад хамрагдаж 50944.0 мянган төгрөг зарцуулсан |
| 3.3.5.7. | Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг туршилтыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим | Үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, үр хойчдоо өвлүүлэн үлдээх, спортлог гэр бүлийг дэмжих, ахмадын хөгжил, оролцоо, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, харваачдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Нумт харвааны аймгийн аварга гэр бүл” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, уг тэмцээнд 13 сумын 24 гэр бүл, 28 хос нийт 100 гаруй харваач авхаалж самбаа, ур чадвар, цэц мэргэнээ сорин оролцож төрөл тус бүрд шилдгүүдийг шалгаруулан алдаршууллаа.Тус тэмцээнд 13 сумын 24 гэр бүл, 28 хос нийт 100 гаруй харваач оролцсон. Аймгийн ахмадуудын удирдлагын зөвлөгөөнд “Ахмад настны тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар сургалт зохион байгуулж 660 ахмад оролцсон. |

| | | |
|---|---|---|
| | үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах | Хойч үедээ үнэт ёс заншил, өв уламжлалаа өвлүүлэн үлдээх зорилгоор “Гэрлэлтийн батлах гардуулах” хүндэтгэлийн арга хэмжээнд 60 жил хамт амьдарсан гэр бүлийн “Очир Эрдэнийн хурим”-ын үйл ажиллагааг зохион байгууллаа.Байгууллгын 100 жилийн хүрээнд Хүүхдийн байгууллагад ажиллаж байсан 80 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, Төрийн одон медалиар 3 ахмад, Монголын залуучуудын холбооны “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч” медалиар 2 ахмад ажилтныг шагнаж урамшуулсан. Мөн хүүхдийн байгууллагад хамгийн олон жил ажилласан 3 ахмадын хөрөг нэвтрүүлгийг бэлтгэж байгуулагын пэйж хуудас, орон нутгийн телевизээр нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлсэн.Үр дүн: Ахмад настныг дэмжих чиглэлээр 3 арга хэмжээнд 852 орчим ахмадыг оролцууллаа. Үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, үр хойчдоо өвлүүлэн үлдээх, спортлог гэр бүлийг дэмжих, ахмадын хөгжил, оролцоо, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, харваачдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Нумт харвааны аймгийн аварга гэр бүл” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, уг тэмцээнд 13 сумын 24 гэр бүл, 28 хос нийт 100 гаруй харваач авхаалж самбаа, ур чадвар, цэц мэргэнээ сорин оролцож төрөл тус бүрд шилдгүүдийг шалгаруулан алдаршууллаа.<br><br>Тус тэмцээнд 13 сумын 24 гэр бүл, 28 хос нийт 100 гаруй харваач оролцсон. Аймгийн ахмадуудын удирдлагын зөвлөгөөнд “Ахмад настны тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар сургалт зохион байгуулж 660 ахмад оролцсон. Хойч үедээ үнэт ёс заншил, өв уламжлалаа өвлүүлэн үлдээх зорилгоор “Гэрлэлтийн батлах гардуулах” хүндэтгэлийн арга хэмжээнд 60 жил хамт амьдарсан гэр бүлийн “Очир Эрдэнийн хурим”-ын үйл ажиллагааг зохион байгууллаа.Байгууллгын 100 жилийн хүрээнд Хүүхдийн байгууллагад ажиллаж байсан 80 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, Төрийн одон медалиар 3 ахмад, Монголын залуучуудын холбооны “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч” медалиар 2 ахмад ажилтныг шагнаж урамшуулсан. Мөн хүүхдийн байгууллагад хамгийн олон жил ажилласан 3 ахмадын хөрөг нэвтрүүлгийг бэлтгэж байгуулагын пэйж хуудас, орон нутгийн |

| | | |
|---|---|---|
| | | телевизээр нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлсэн.Үр дүн: Ахмад настныг дэмжих чиглэлээр 3 арга хэмжээнд 852 орчим ахмадыг оролцууллаа |
| 3.3.5.8. | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.2.6-д заасан ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг батлуулан хэрэгжүүлэх | Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон, мөн хүүхэд байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн, хорих ангиас суллагдсан, нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагатай, гэр оронгүй иргэн нийт 40 иргэнд 48000,0 мянган төгрөгийн онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийг олгосон. |
| 3.3.5.10. | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна”. Гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллуулах | АЗДТГ дээр 1 тэтгэвэрт гарсан ажилтан ажиллаж байна. Байгууллагуудад мэдээ мэдээлэл өгч хэрэгжүүлэх тал дээр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. |

| | | |
|---|---|---|
| 3.3.5.11. | Ахмад настны эсрэг гэр бүлийн хүчирхийлэл, тэтгэвэр, тэтгэмж, эдийн болон эдийн бус хөрөнгийн эзэмших, ашиглах эрхийн зөрчил, гэм хорын талаар мэдээлэх дуудлагын тусгай утсыг ажилуулах, утасны дугаарыг иргэд, олон нийт, ахмад настанд таниулан хүргэх | |
| 3.3.5.12. | Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх байгууллагад газар эзэмшүүлэх талаар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусган дэмжлэг үзүүлэх | Хүсэлт байхгүй. |
| **3.4.** | **Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | |
| 3.4.1. | Хөтөлбөрийн 2.1.1.18 дахь заалтын дагуу ахмад настанд Гэр бүлийн цогц төвөөр дамжуулан, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхитэй насжилтыг дэмжинэ. | Ахмадын асаргааны хувилбарт үйлчилгээнд 172 хүн хамрагдаж, 37564.0 мянган төгрөгийг шилжүүлсэн. Ахмадын насжилтыг дэмжих төвийн үйлчилгээнд 2281 ахмад хамрагдаж, 50944.0 мянган төгрөгийг шилжүүлсэн.Идэвхитэй насжилтыг дэмжих цогц төвийн үйлчилгээнд лавлагаа мэдээллийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах үйлчилгээ, сайн дурын үйлчилгээ, зөв хооллолт, эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг дэмжих үйлчилгээнүүд орсон.<br><br>Аймгийн хэмжээнд Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв байхгүй боловч газрын зүгээс нөөц боломждоо тулгуурлан төр болон хувийн |

| | | |
|---|---|---|
| | | хэвшилтэй хамтран ажилласан. “Тусч хүч” ТББ-тай гэрээлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалагчид нийт 108 гэр бүлийн 120 иргэнд бүлгийн болон ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлсэн. Баруун-Урт сумын ЗДТГазрын дэргэдэх сэтгэл зүйн төвөөр дамжуулан гэр бүлийн маргаантай асуудлаар 5 гэр бүлд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн өндөр настан 2, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэй 12, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд 21, гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн 9 эцэг эх асран хамгаалагч, гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны 9 хүүхдэд нийт 157 гэр бүлд гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээг үзүүлэн ажиллаа. Үүнд: Эрүүл мэнд, Хууль эрх зүй, Нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө, Хөгжлийн үйлчилгээ, Хөдөлмөрт холбон зуулчлах, Аюулгүй байдлыг хангах зэрэг чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагатай холбон үйлчилж цогц үйлчилгээгээр хангаж ажиллаа. |
| 3.4.2. | Үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.7 заалтын дагуу сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулж ажиллана. | Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан томилогдон ажиллаж байгаатай холбогдуулан мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Үүнд: Хэнтий аймагт зохион байгуулагдсан “Нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах” бүсийн сургалтад 13 нийгмийн ажилтан, аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран Хамтарсан багийн 90 гишүүнийг оролцуулан чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, сургагч багшаар Л.Бадамцэцэг оролцсон. Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газартай хамтран 9 багийн 25 гишүүнийг хамруулан хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”- гээр ажлын байранд чадавхижуулах сургалтыг явуулж, 172 гишүүнийг хамруулан, арга зүйгээр ханган ажилласан нь чухал ач холбогдолтой ажил арга хэмжээ байлаа. Хамтарсан багийн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах, кейс хариу үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, туршлага, мэдээлэл солилцох зорилгоор хамтарсан багийн гишүүдэд сар бүр, шаардлагатай тохиолдолд шуурхай “Кейс хэлэлцүүлэг”-ийг танхимаар 19 удаа, цахимаар 14, нийт 33 удаа зохион байгуулсан. Үр дүн: Хамтарсан багийн гишүүдэд арга зүй өгөх кейс хэлэлцүүлгийг 33 удаа, чадавхжуулах сургалтыг 4 удаа зохион байгуулсан. Тайлант хугацаанд |

| | | |
|---|---|---|
| | | аймгийн хэмжээнд нийт 475 хүүхдийг хамгааллын үйлчилгээнд хамруулж зохих үйлчилгээг үзүүлсэн. “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд Асгат, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын нутаг дэвсгэрийг дамжин гарсан хээрийн түймэрт өртөж гэр нь шатсан 9 өрхийн 13 хүүхдэд, Халзан, Уулбаян сумдын нутгийг хамарсан цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас аадар бороо, мөндөрт цохигдон, орон гэргүй болсон 21 өрхийн 55 хүүхдэд хуульд заасны дагуу тухайн орон нутгийн Хамтарсан багийн гишүүд газар дээр нь ажиллаж, гамшиг онцгой нөхцөл байдлын үеийн түргэвчилсэн үнэлгээг хийж хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн. Одоогоо эрсдэлийн программд нийт 1382 хүүхэд бүртгэлтэй байна. |
| 3.4.3. | Хөтөлбөрийн 2.1.1.8 дахь заалтын дагуу хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтлан ажиллана. | Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд Эрдэнэцагаан суманд “Багачуудын ордон” хүүхэд харах үйлчилгээний төв ажиллаж байгаа бөгөөд тус төвд 15 хүүхэд, 3 хүүхэд харагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсан.<br>Хүүхэд харах үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж 5 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж ажилласан. жилийн эцсийн байдлаар хүүхдийн эрхийн гэмт хэрэг 12 хувиар буурсан байна. |

| | | |
|---|---|---|
| 3.4.4. | Хөтөлбөрийн 2.1.1.4 заалтын дагуу Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг хүн амын бүлгүүдийн хөгжлийн болон соёлын төв, иргэний танхимыг түшиглэн байгуулж, бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ | "Түр хамгаалах байр" болон газрын дэргэдэх зөвлөгөө өгөх төв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн туслах үйлчилгээ үзүүлдэг "Тусч хүч" ТББ, Баруун-Урт сумын дэргэдэх "Зөвлөгөө өгөх төв" зэрэг төвүүдээр дамжуулан 326 иргэнд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилсан.<br>Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан 26 удаагийн арга хэмжээ, бүлгийн уулзалт, ганцаарчилсан зөвлөгөө зэрэгт нийт гэр бүлийн 40.1% буюу 7891 өрх, гэр бүлд хүрч ажилласан.<br>Мөн гэр бүлийн маргаантай асуудлаар 4 иргэн, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн өндөр настан 2, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 21, гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн 12 эцэг эх, асран хамгаалагч, гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны 12 хүүхэд, нийт 39 хүнд хууль зүйн зөвлөгөө өгч, хамтарсан баг болон өмгөөлөгчтэй холбон зуучлах арга хэмжээ зохион байгуулсан.<br>Хариу үйлчилгээнд хамрагдсан 20 өрхөд түлээ нүүрсний дэмжлэг үзүүлэв.<br>Үр дүн: 26 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, нийт өрхийн 40,1% буюу 7891 өрхөд хүрч ажиллан, 20 өрхөд дэмжлэг үзүүлсэн. |
| 3.4.5. | Хөтөлбөрийн 2.1.1.12 заалтын дагуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх орон нутгийн төлөвлөгөөг баталж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ. | Энэ жил төсөв батлагдаж ирээгүйтэй холбоотойгоор эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ажил хэрэгжээгүй. |

| | | |
|---|---|---|
| 3.4.6. | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт 2.1.1.26-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамламж үйлчилгээний чанарыг сайжруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна. | 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комис 24 удаа хуралдаж 201 хүүхэд орж, 44 хүүхэд асаргаанд шинээр хамрагдаж, 18 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болохыг шинээр тогтоож, 139 хүүхдийн асаргаа сунгагдсан. Мөн 31 хүүхдийг живхний хөнгөлөлтөд хамрагдах шийдвэр, 81 хүүхдийг хүнд хэлбэрийн бэрхшээлтэй болохыг тодорхойлсон шийдвэрүүдийг тус тус гаргасан. 2. Улаанбаатар хотын Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн 19 чиглэлийн эмчийн үзлэг оношилгоонд Сүхбаатар аймгаас зорилтод бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхдийг асран хамгаалагчийн хамтаар нэгдсэн унаагаар үйлчилж байр хоолны зардал болон 3.2 сая төгрөг АЗДТГазраас шийдвэрлэж хамруулсан. 3. Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, Ариун Бичээс нийгэмлэг Сүхбаатар аймгийн ЗДТГазар, Хөдөлмөр, халамжийн үйчилгээний газар хамтран харааны бэрхшээлтэй 15 иргэнд брайль бичгийн сургалтад хамруулсан. ГБХНХЯам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас "Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалт"-д төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл нийт 30 төлөөлөл хамрагдаж гэрчилгээ олгосон.<br>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөрлөгийг 100 гаруй хүнд зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагууд үйлчилгээгээ нээлттэй, ил тод хүргэж, сургалт мэдээлэл өгсөн.<br>5. Халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөд 967 хүнд 209567.5 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олгосон. |

| | | |
|---|---|---|
| 3.4.7. | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт 1.4.1.1.-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутгийн нэмэгдлийг төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 2 хувиар тооцож, улсын төсвөөс, төрийн захиргааны албан хаагчид 80 хувь хүртэл нэмэгдүүлэх эрхийг аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэнэ. | Босоо удирдлагатай агентлагт 10 хувь, бусад байгууллагад нь 20 хувь байна. |